

“ҮНДСЭНДЭЭ ЭРХ ЧӨЛӨӨГҮЙ”

Александр Поливанов

2006 оны байдлаар Орос улсыг эдийн засгийн эрх чөлөөний үүднээс авч үзвэл өөрчлөгдсөн зүйл бараг үгүй бөгөөд дэлхийн рейтингд 122-р байрнаас 120-д орж үндсэндээ эрх чөлөөгүй улсуудын тоонд орсоор хэвээр үлджээ. Авилгал хээл хахууль, хөрөнгө оруулалтын таатай бус нөхцөл болон хувийн өмчийн эргэлзээтэй эрх зэрэг нь Орос улсыг Бенин, Лесото, Гондурас зэрэг улсуудаас дээш гарах боломж олгосонгүй.

Эдийн засгийн салбарт явагддаг олон улсын рейтингээр Орос улст жилээс жилд атаархамааргүй байр оногддог гэж хэлэхэд хилсдэхгүй. Авилгалын түвшингээр тус улс нь Свазиленд, Гондурас, Руанда зэрэг улсуудын дунд, харин амьдралын өртөгөөр Лив, Македони улсуудын дунд байр эзэлдэгт бид хэдийнээ дасал болжээ.

Америкийн судалгааны Heritage Foundation фонд болон The Wall Street Journal сэтгүүлийн хамтарсан судалгаа нь Оросын эдийн засгийн үйл явц засгийн газрын хүссэн хэмжээнд хүрэхгүй байгааг болон эдийн засгийн уламжлалт рейтингийг харуулжээ.

Тус фондын шинжээчид улс орнуудыг 10 үзүүлэлтээр үнэлдэг: авилгал, мөнгө санхүүгийн эрх чөлөөнөөс засгийн газраас хараат бус бизнесийн эрх чөлөө хүртэл гэх мэт. Heritage Foundation-ны шинжээчдийн үзэж байгаагаар, 13 жилийн турш явуулсан судалгааны үр дүнд эдийн засгийн эрх чөлөө өссөн улс орнуудын амьдралын түвшин илүү хурдан өсдөг гэсэн дүгнэлт гарчээ.

2007 оны судалгаанд судлаачид тооллогын арга зүйг бага зэрэг өөрчилсөн. Энэ нь рейтингийн ихэнхи хувьд ямар нэгэн нөлөө үзүүлсэнгүй. Гэхдээ Япон болон Бельги улсуудын байдал энэхүү шинэ аргачиллын үр дүнд огцом өссөн бол Швед ба Австрийнх доошилсон байна.

Гонконгоос Солонгос хүртэл.

Heritage Foundation улс орнуудыг үндсэн 5 ангиллар байр эзлүүлжээ. Үүнд: “эдийн засгийн эрх чөлөөт”, “үндсэндээ эрх чөлөөтэй”, “дундаж эрх чөлөөтэй”, “үндсэндээ эрх чөлөөгүй” болон “дарангуйлагдсан эдийн засагтай”.

Нийт үзүүлэлтээр эхний байранд авах боломжтой 100 онооноос 89,3 оноо авснаар Гонконг оржээ. Хятадын засаг захиргааны тусгай бүс болох энэ улс ойрын өрсөлдөгчидөө нэлээд ард хаяж чадсан байна. Хоёрдугаар байранд орсон Сингапур ердөө 85,7 оноо авсан бол

“хүрэл” байрт Австрали 82,7 оноо авчээ.

Рейтингийн хамгийн сүүлд мэдээж дарангуйлагч дэглэм тогтсон хаалттай гэгдэх социалист орнууд орсон байна. Сүүлийн байрыг Хойд Солонгос эзэлсэн бол түүний өмнө Куба оржээ.

Судан, Серби, Конго, Ирак зэрэг 4 улс ямар ч рейтинг аваагүй байна. Энэ нь африкийн орнууд болон Иракт дайны үйл ажиллагаа явагдаж байгаатай холбоотой. Серби улс рейтинг аваагүй нь ийм нэртэй улс зөвхөн 2006 онд байгуулагдсантай холбоотой бөгөөд үүнээс өмнө Черногори түүний бүрэлдэхүүнд багтаж байжээ.

Бусад улс дотроос Норвегийг онцолж хэлэх хэрэгтэй, яагаад гэвэл энэ улс зөвхөн 30-р байр эзэлсэн бөгөөд бусад рейтингээр амьдралын түвшингээр хамгийн өндөрт ордог орон байна. Бизнесменуудын хувьд харин тийм биш бололтой.

Хятадын эдийн засаг урьдынх шигээ нэлээд эрх чөлөөгүй гэсэн үнэлгээ авч 119-р байранд орж, энэхүү эрх чөлөөгүй гэсэн тодотгол нь өмчийн эрхт хамаатай бөгөөд авилгалаас үүдэлтэй юм. Оросын худалдааны томоохон түнш Герман улс 19-р байранд оржээ. Үүнээс дээшээ гарахад эдийн засаг нь улсаас нэлээд хараат байдалтай байдаг ба өндөр татвар зэрэг сөрөг нөлөөлжээ.

Тус фондын онцолсноор, дэлхий ертөнцөд тэмүүлэх зүйл байсаар хэвээрээ байгаа бөгөөд эдийн засгийн эрх чөлөөний дундаж үзүүлэлт 60.5 онооноос хэтрэхгүй байна. Эхний 20 байранд Европын 12 орон орсон бол Өмнөд ба Хойд Америкаас 3, Номхон далайн бүсээс 5 орон орсон үзүүлэлт гарчээ.

Топ-20-ийн баримтаас үзвэл, ямар тив бизнесийн хувьд хамгийн таатай болохыг тогтооход ядах юм алга. Үүнээс үзэхэд, Европ 67.5 оноогоор эхний байранд орсон бол Хойд ба Өмнөд Америк 62.3%-иар хоёрдугаар байранд орсон байна. Дэлхийн дундаж үзүүлэлтээс доогуур байрыг Номхон далайн бүс, Ойрхи Дорнод болон Африк эзэлжээ.

Оросын Холбооны Улс

ОХУ Heritage Foundation-ны рейтингэд 120-р байранд орж Хятад Непалын дунд байр эзэлсэн нь “үндсэндээ эрх чөлөөгүй” гэсэн ангилалд хамаарч байна. Өнгөрсөн оныхтой харьцуулбал тэрээр бүхэл бүтэн 2 шат ахисан үзүүлэлт гарчээ. Иймэрхүү аястай явбал ОХУ 60 жилийн дараа л тус рейтингийн 1-р байранд орно гэсэн үг. Тэргүүлэгчдийн эгнээнд хүрэхэд маш хол хэвээр байгаа бөгөөд ОХУ Европын 41 орноос 39-т ордог ба ардаа ердөө Украин, Белоруссийг л орхиж чаджээ.

Ерөнхий сөрөг байдлыг тооцохгүй бол ОХУ-д баярлах үндэслэл бас байгаа бөгөөд дэлхийн дундаж үзүүлэлтийн 10 ангиллаас ОХУ 3 ангиллаар тэргүүлж байгаа явдал юм. Энэ нь юу гэвэл, бизнесийн эрх чөлөөний үнэлгээгээр 100 оноо авахаас тус орныг 66.6 оноогоор үнэлжээ. Судалгаанд тэмдэглэснээр, өөрийн бизнесийг эхлэхэд ОХУ-д 28 хоног л хангалттай байхад дэлхийд дунджаар 48 хоног шаардлагатай байдаг байна.

Татварын эрх чөлөөний хувьд ОХУ нь дэлхийн нийт үзүүлэлтийг бага татвараар тэргүүлдэг агаад Оросын иргэн бүр ашгийн татварын 13%-ийг л төлдөг байна. Мөн бас нэг гайхалтай гэж хэлж болох зүйл гэвэл ОХУ-ын эдийн засаг улсаас хараат бус түвшингээр нэлээд өндөр байр эзэлж 71.6%-иар дэлхийн дундаж үзүүлэлттэй бараг тэнцэх үзүүлэлттэй байна.

Үүнээс гадна ОХУ ажлын хүчний зах зээлийн эрх чөлөөгөөр дэлхийд тэргүүлжээ. Харин авилгал, хөрөнгө оруулалтын эрх чөлөө болон өмчийн эрхийн хувьд тус улс рейтингийн бараг сүүлийн байрыг эзэлжээ. Эрх зүйн систем нь нэвт хээл хахуульд идэгдсэн бөгөөд орон нутгийн эдийн засагт хөрөнгө оруулахад албан болон албан бус хорио цээр саад болсоор хэвээр байна.

Оросын банкны систем мөн ширүүн шүүмжлэлд өртжээ. Heritage Foundation-ны онцолсноор, 1998 онд санхүүгийн хямрал болж, одоо үйл ажиллагаа явуулж буй мянгаад банкуудын ихэнхи нь жижиг банк бус санхүүгийн байгууллага байдаг байна.

Хөршүүд

ОХУ олон хөрштэй бөгөөд тэдгээр нь 12 /Эстони/-оос 145/ Беларусь/-р байр эзэлдэг ажээ. Heritage Foundation-ны мэргэжилтнүүд Прибалтикийн улсуудын эдийн засгийн эрх чөлөөг өндрөөр үнэлжээ. Жишээлбэл, Эстони ОХУ, Мадагаскар, Гана, Йемен зэрэг улсуудыг тэргүүлээд зогсохгүй мөн Герман /19-р байр/, Япон /18-р байр/, Испани /27-р байр/ зэрэг улсуудаас дээгүүрт оржээ.

Хөрш орнуудын дунд эдийн засгийн эрх чөлөөний хувьд хамгийн доогуур үзүүлэлттэй байгаа нь Беларусь улс юм. Өөрийн бизнесийг эхлэхэд Беларусыг 68 хоног шаардлагатай байдаг байна. Тэгсэн хэдийд ч Беларусь их хэмжээний гадаадынхныг татах бололцоогүй орон юм, учир нь энд санхүүгийн болон хөрөнгө оруулалтын эрх чөлөө бараг байхгүй бөгөөд өмчийн эрх маш доод үзүүлэлттэйн дээр хүнд суртал хээль хахууль өндөр хэмжээнд хүрсэн байна. Харин ОХУ-тай адил, Беларусст бизнесийн улсаас хараат бус эрх чөлөө нэлээд өндөр хувьтай байдаг бөгөөд 100-аас 66.9 оноотой байдаг ажээ.

“Улбар шар” хувьсгал гарсан ч Украин Белорусаас нэг их хол явж чадсангүй. Украины хувьд ОХУ болон Белорусьтай мөн адил хүндрэл байдаг хийгээд авилгал ба бага татварын орчинд хөрөнгө оруулалтын доогуур үзүүлэлт гэх мэт.

Ийм мэтийн рейтинг гаргаснаар байдал огцом өөрчлөгдөж дээрдэхгүй нь тодорхой, учир нь оросын, украины болон белоруссын албан тушаалтнууд хээл хахууль авахаа больж шударга бизнес явуулахад саад тотгор учруулахгүй гэх баталгаа алга. Гэвч ийм мэтийн рейтинг бага ч гэсэн нэмэр болох учиртай, өөрийн орныг дэлхийн рейтингийн ёроолд байхыг харахад хэнд ч болтугай сайхан сэтгэгдэл төрөхгүй нь лавтай.

Эх сурвалж: [www./lenta.ru/articles/2007/01/16/rating](http://lenta.ru/articles/2007/01/16/rating)

*Орос хэлнээс орчуулсан ОУСХ-ийн
эрдэм шинжилгээний ажилтан Ж. Орхон*